

ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2025 оны 02 сарын 12 өдөр

№ 04

Улаанбаатар хот

Энэхүү Хамтран ажиллах санамж бичгийг (цаашид “Санамж бичиг” гэх)

Нэг талаас: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпын -10 хаягт байрлах Монгол Улсын Гадаад харилцааны яамны харьяа “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” ТӨҮГ /РД: 5112303, цаашид “ДБҮЭГ” гэх/, түүнийг төлөөлж захирал Б. Халиун;

Нөгөө талаас: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп гудамж, Очир төв, 5 -рт давхар, 503 тоот хаягт байрлах “Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо НЭЗХЭ /цаашид “АЖМХ НЭЗХЭ” гэх, РД: 8398801, түүнийг төлөөлж Ерөнхийлөгч Т. Баттулга нар доор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Санамж бичгийн зорилго

1.1. Энэхүү Санамж бичгийн зорилго нь талууд Монгол улсын засгийн газраас 2023-2028 оныг “Монголд Зочлох Жил” болгон зарласантай холбогдуулан Монгол ахуй, соёл, өв уламжлалыг жуулчдад сурталчлан таниулах, соёлын биет болон биет бус өвийг хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор хамтран ажиллахад оршино.

Хоёр. Хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ

Талууд хамтран ажиллах ажлын хүрээнд:

- 2.1 Монгол Улсын Соёлын биет өв болсон Чин Ван Ханддоржийн өргөөг жуулчид, зочид төлөөлөгчдөд сурталчлан таниулах,
- 2.2 “Монгол гэрийн онцлог, өв соёлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Соёлын тусгай арга хэмжээ, хөтөлбөр”-ийг хамтран хэрэгжүүлэх,
- 2.3 Нүүдэлчдийн ахуй соёл, ёс заншлыг таниулах зорилгоор Чин Ван Ханддоржийн өргөөнд Монгол үндэсний зоог гүнцэгээр жуулчид, зочид төлөөлөгчдөд үйлчлэхэд хамтран ажиллах,
- 2.4 Жуулчид, зочид төлөөлөгчдөд мэргэшсэн жолооч бүхий найдвартай, тав тухтай автомашины үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах,
- 2.6 Хамтын ажиллагааны ерөнхий чиглэл, цар хүрээ, дэвшилтэт санаа, үр дүнгийн талаар санал мэдээлэл солилцох, харилцан тохиролцох

Гурав. Холбоо барих болон Санамж бичгийн хугацаа

3.1. Талууд санамж бичигтэй холбоотойгоор харилцахдаа доорх хаяг мэдээллийг үндэслэнэ.

3.1.1. ДБҮЭГ -ын мэдээлэл

- а) Утас: 976-11-328409, 99057086
- б) Цахим шуудан: director@dipservice.gov.mn
- с) Харилцах этгээд: Үйлчилгээний алба

3.1.2. АЖМХ НЭЗХЭ мэдээлэл

- а) Утас: 976-11-77128822
- б) Цахим шуудан: info@mto.mn
- с) Харилцах этгээд: Ажлын алба

3.2. Хэрэв талуудын аль нэг нь энэхүү санамж бичгийн 3.1-т заасан мэдээлэлдээ өөрчлөлт оруулах бол нөгөө талдаа ажлын 14 хоногийн дотор аливаа хэлбэрээр мэдэгдэж баталгаажуулна.

3.3. Санамж бичгийг талууд 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 2028 оны 02 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл нийт 3 /гурван/ жилийн хугацаатай байгуулав.

3.4. Энэхүү санамж бичгийн хугацааг талууд харилцан тохиролцон сунгаж болно.

Дөрөв. Хариуцлага

4.1. Хамтын ажиллагааны явцад аль нэг талын гишүүнээс гомдол гаргах нь Санамж бичгийг цуцлах, хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй бөгөөд гомдлыг эвийн журмаар зөвшилцөж шийдвэрлэхэд талууд үлэмж чармайн хичээж ажиллана.

4.2. Санамж бичгийн хэрэгжүүлэх явцад талуудын аль нэгэнд хохирол учирсан тохиолдолд талууд тухайн хохирлыг боломжит хугацаанд хамтран барагдуулах (аль нэг талын санаатай буруу үйлдлээс болсон тохиолдолд тухайн буруутай тал) бөгөөд энэ нь санамж бичгийг хүчин төгөлдөр бус гэж тооцох, эсхүл шууд цуцлах үндэслэл болохгүй.

Тав. Бусад зүйл

5.1. Талууд санамж бичигт дурдсан асуудлын хэрэгжилтийн явц, биелэлтийг харилцан мэдээлж, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч ажиллана.

5.2. Талуудын удирдлага өөрчлөгдсөнөөс үл хамааран Санамж бичиг нь үйлчлэх хугацааны туршид хүчин төгөлдөр байна.

5.3. Талууд Санамж бичгийн биелэлтийг жил бүрийн 12 дугаар сард багтаан дүгнэнэ.

5.4. Энэхүү Санамж бичгийг 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Монгол хэл дээр 2 хувь үйлдсэн бөгөөд эх хувь тус бүр нэгэн адил хүчинтэй байна.

САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН

